

МОНГОЛ УЛС ҮНДЭСНИЙ ТӨЛБӨРИЙН КАРТТАЙ БОЛЛОО

Бэлэн бус гүйлгээнд АНУ-ын Виза /Visa/, Мастер /Master/ картаар бус харин Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгийг бэлгэдсэн үндэсний төлбөрийн “Т карт”-ыг ашиглах боллоо.

Монголбанкны Үндэсний цахим гүйлгээний төв 2010 оны зургадугаар сараас “Банк хоорондын төлбөрийн картын нэгдсэн сүлжээ”-г нэвтрүүлснээр карт эзэмшигчид аль ч банкаар үйлчлүүлэх боломжтой болсон. Өөрөөр хэлбэл өмнө нь “Хадгаламж” банкны картыг зөвхөн “Хадгаламж” банкны АТМ уншина гэх мэтээр зөвхөн тухайн банкныхаа хүрээнд хязгаарлагддаг байсан юм. Энэ нь мөн үйлчилгээний байгууллагуудад ашигладаг карт уншигч ПОС машинуудад хамаарч, “Худалдаа хөгжил”, “Хаан”, “Толомт”, “Хадгаламж” гээд бүх л карт гаргагч банкны машиныг байлгах шаардлага гардаг байсан. Харин дээр дурдсанчлан төлбөрийн картын нэгдсэн сүлжээнд холбосноор бэлэн бус төлбөр тооцоог дэмжих, тэр дундаа төлбөрийн картын үйлчилгээг хөгжүүлэх хөдөлгөгч хүч болсон гэж Монголбанкаас онцолж байгаа юм.

Монголбанкаас хийсэн судалгаагаар 2011 оны эцсийн байдлаар карт эзэмшигчдийн тоо 2,1 сая гаруйд хүрч, 3,6 их наяд төгрөгийн 44,8 сая ширхэг гүйлгээ хийгдсэн тоо гарчээ. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 65,8 хувь буюу 17,9 сая ширхэгээр нэмэгдсэн үзүүлэлт юм байна.

Төлбөрийн картын нэгдсэн сүлжээгээр 1,5 жилийн хугацаанд нийт 254 тэрбум төгрөгийн дүнтэй 5,5 сая ширхэг банк хоорондын картын гүйлгээ дамжин боловсруулагджээ.

Харин энэ удаад Монголбанкны зүгээс картын үйлчилгээг иргэдэд илүү хүртээмжтэй, түргэн шуурхай хүргэх бодлогын хүрээнд банкуудтай хамтран дахин нэг томоохон төлөвлөгөөт ажил хэрэгжүүлснээр өчигдөр танилцууллаа.

Уг ажлын хүрээнд Монгол Улс өөрийн гэсэн үндэсний төлбөрийн карттай болж байгаа аж. Өөрөөр хэлбэл бусад улс орны нэр, лого бүхий Виза, Мастер картны оронд үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгийг бэлгэдэн нэршсэн “Т карт” хэмээх төлбөрийн картыг хэрэглэх болж байгаа юм байна.

Үндэсний төлбөрийн “Т карт”-ын нээлтийн ажиллагаанд өчигдөр Монголбанкны дэд ерөнхийлөгч Н.Золжаргал, Төлбөр Тооцоо, бүртгэлийн газрын захирал М.Амгалан, Үндэсний цахим гүйлгээний төвийн захирал Ж.Цогтсанаа, “Худалдаа хөгжлийн банк”-ны гүйцэтгэх захирал Б.Мэдрээ, гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч Л.Соронзонболд нар оролцов.

Монголбанкны дэд ерөнхийлөгч Н.Золжаргалаас “Т карт”-ын талаар тодрууллаа.

- Үндэсний төлбөрийн картыг нэвтрүүлэх болсон шалтгаан юу байв? Энэ картын онцлог?

-Монгол Улсад кредит карт буюу картын үйлчилгээ нэвтрээд олон жил болж байна. Сүүлийн жилүүдэд бүр ч эрчимтэй хөгжиж, төлбөр тооцоонд кредит карт хэдийнэ байр сууриа олсон. 2010 онд нэвтрүүлсэн “Банк хоорондын төлбөрийн картын нэгдсэн сүлжээ” бидний ажлыг урагшлуулах нэг том алхам болсон бол энэ ажлын үргэлжлэл, нэг хэсэг болох үндэсний брэнд “Т карт”-ыг гаргалаа. Тухайлбал АНУ Виза /Visa/, Мастер /Master/, Американ Экспресс /American express/, БНХАУ

Юнион пей /Union pay/, Япон Улс ЖиСиБи /JCB/ гэсэн үндэсний төлбөрийн картуудтай. Харин манай улс өнөөг хүртэл АНУ-ын Виза, Мастер картуудыг тодорхой төлбөр төлж, бэлэн бус гүйлгээндээ ашиглаж ирсэн юм. Одоо “Т карт” буюу үндэсний төлбөрийн карт нэвтэрснээр бид гадны орнуудад төлбөр төлөхгүйгээр дотоод хэрэгцээний картаа дотооддоо гаргаж, Монголбанкнаасаа зөвшөөрөл авч ашиглах бүрэн боломжтой болж байгаа юм.

“Т карт” эзэмшигчид эхний ээлжинд тус төлбөрийн картаар дотооддоо гүйлгээ хийх бөгөөд цаашид олон улсын хэмжээнд хэрэглэх боломжтой болох юм. Гол нь уг карт хэрэглэгчдэд үндэснийхээ үзлийг дээдлэх, бахархах сэтгэгдлийг төрүүлж, өөрсдийгөө гадныханд сурталчлан таниулах том хэрэгсэл болж, Монгол Улсын иргэдийн төлбөрийн картаар үйлчлүүлсэн төлбөр тооцоо, мөнгөн урсгал болон банкуудын гадаад руу чиглэсэн их хэмжээний хөрөнгийг дотооддоо хадгалах зэрэг эдийн засгийн ихээхэн үр ашиг авчрах онцлогтой.

-Арилжааны банкууд “Т карт”-ыг зөвшөөрөл авч гаргах юм байна. Өмнө нь Виза, Мастер картуудад хэр хэмжээний төлбөр, ямар журмаар төлдөг байсан юм бэ?

-Үндэсний төлбөрийн картыг гаргагч анхны банк “Худалдаа хөгжлийн банк” болж байгаа юм. Одоогийн байдлаар тус банкнаас гадна хэд хэдэн банк “Т карт” төлбөрийн картыг дотооддоо гаргах зөвшөөрлийг Монголбанкнаас аваад байна.

“Худалдаа хөгжлийн банк”-ны хувьд Монголбанкны ерөнхийлөгчийн гарын үсэг бүхийн зөвшөөрлийг өнөөдөр /өчигдөр/ гардаж авлаа.

Виза, Мастер карт хэвлэхэд банкууд төрөл хэлбэр, серийн дугаар бүрээ АНУ дахь толгой банкинд мэдээллэх, зөвшөөрөл авах, тодорхой хэмжээний татвар төлөх шаардлагатай байдаг юм. Карт бүрийн гүйлгээ бүрээс 0.2 хувийн шимтгэл авдаг. Үндэсний төлбөрийн картгүй байсан учраас л арга буюу Виза, Мастер картыг хэрэглэж байсан юм. Харин одоо бол шимтгэл, зөвшөөрөлд төлж байсан мөнгөө арилжааны банкууд хэмнэж, картын хэрэглэгчиддээ илүү ойрхон үйлчилгээ үзүүлэхэд хөрөнгөө оруулж эхлэнэ гэж харагдаж байгаа.

-Үндэсний төлбөрийн картыг цаашдаа олон улсад хэрэглэх боломжтой болно гэж та түрүүн хэллээ. Энэ талаар тодруулаач?

-Бидний хийж буй олон шатлалтай ажлын зорилго нь эцсийн дүндээ дэлхийн хамгийн өндөр түвшний төлбөр тооцооны системтэй улс болоход оршиж байна. Энэ ирээдүй маань ч тийм холгүй байгаа болов уу. Үндэсний брэнд “Т карт” бол үүний нэг хэсэг юм. Дараагийн шатны үйл ажиллагаа бол “Мобайл банк” буюу хөдөлгөөнт банкны системийг нэгтгэх, улсын хэмжээнд нэгдсэн сүлжээгээх хэрэглэж болдог систем рүү оруулахад чиглэгдэнэ.

Хөгжиж буй улсуудын төлбөр тооцооны системийн адил, тэдний хэрэглээний түвшинд “Мобайл банк”-ыг бид ойрын нэг жилд багтаан хүрч чадах байх гэсэн төлөвлөгөөтэй байна. Иргэд маань гар утаснаасаа бүх төлбөр тооцоогоо хийдэг цаг ойрхон ирчихээд байгаагийн илрэл нь үндэсний брэнд “Т карт” юм.

Цаашид Монголбанк үндэсний “Т карт” төлбөрийн карт дээр тулгуурлан Төрийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад карт уншигч ПОС терминал байршуулах замаар

төрийн үйлчилгээг иргэдэд зардал чирэгдэлгүй хүртээмжтэй хүргэх зэрэг өргөн цар хүрээтэй ажлуудыг хийхээр төлөвлөөд байна.

-Бэлэн бус мөнгөний гүйлгээ нэмэгдүүлэх нь эрсдлээс гадна өөр олон ямар давуу талтай байж болох вэ?

-Кредит картны үйлчилгээг Монголын эдийн засагт нэвтрүүлж, энэ картаараа голчлон хийдэг болох нь бидний зорилго юм. Үүндээ хүрчихвэл, дээр нь “Мобайл банк”-ны үйлчилгээг зах зээлд бүрэн дүүрэн нэвтрүүлчихвэл Монголын төлбөр тооцооны систем илүү ойлгомжтой, найдвартай, ил тод болж байна гэсэн үг. Наад зах нь үйлчилгээний байгууллагууд картаар үйлчилсэн тохиолдолд татвараас зугтах мөнгө самшигдуулах ямар ч боломжгүй байдаг юм.

Мөн картын хэрэглээ нэмэгдсэнээр бэлэн мөнгөний төлбөр тооцоо багасч, далд эдийн засгийг бууруулах гарц болох юм.

“Худалдаа хөгжлийн банк”-ны гүйцэтгэх захирал Р.Мэдрээгээс “Г карт”-ыг хэрэглэгчдэд хэрхэн хүргэх талаар тодрууллаа.

-“Г карт”-ын нууцлал, аюулгүй байдалд хэрхэн анхаарлаа хандуулж байгаа вэ?

-Өнөөг хүртэл бид Виза, Мастер картыг 20 гаруй жилийн турш хэвлэж, хэрэглэгчиддээ хүргэж ирсэн. Энэ хугацаанд картын ашиглах горим, нууцлал, үзүүлэлт зэрэгт хангалттай гэж хэлж болох туршлага хуримтлуулсан. “Г карт”-ын хувьд бүх үзүүлэлт нь дээрх нэр бүхий картуудтай ялгаагүй байна.

-Картыг ямар ямар төрөл болон хэдэн төгрөгийн хураамжтай гаргах вэ?

-Төрлийн хувьд одоо энгийн, алтан, лэйди, цалингийн гээд одоо хэрэглэгдэж байгаатай адил гарна. Хураамж ч адил байна. Харин Visa, Master гэсэн тэмдэгийн оронд үндэсний мөнгөн тэмдэгтийг илтгэсэн “Г” симбол болон их гүрний үеийн Гэрэгэг харуулсан дүрслэл бүхий хэрэглэгдэхүүнтэй байх юм.

Харин хэрэглэгчдийн гар дээр ирэх сарын дундуур гэхэд хүрч эхэлнэ.